ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

## Айраг сумын Засаг даргын Тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** ДГА-2021/3/СТА-ТШ3


Цахим хуудас: www.dornogovi.audit.mn

Дорноговь аймаг

2021 он

Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий

Утас: 70522734 Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn

Аудитын менежер: У.Оюунтүлхүүр

Утас: 70523020 Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn

Аудитор: Т.Мөнхтогтох

Цахим хаяг: munkhtogtokht@audit.gov.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд байгууллагын Олон улсын стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |
| ДГА | Дорноговь аймаг |
| ЗГНХ | Засгийн газрын нөөц хөрөнгө |
| ЗДНХ | Засаг даргын нөөц хөрөнгө |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| УСНББОУС | Улсын секторын Нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт |
| ҮОМШӨ | Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин |

## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт ........ 3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан ........ 5
2.1.Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ........ 5
2.2.Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ........ 6
2.3.Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ........ 8
2.4.Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ........ 10
2.5.Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ........ 11
2.6.Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан ........ 13
3.Аудитын тайлан ........ 14
3.1.Ерөнхий зүйл ........ 14
3.2.Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй ........ 14
3.3.Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт ........ 15
3.4.Материаллаг байдал ........ 15
3.5.Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд ........ 15
3.6.Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт ........ 16
3.7.Шилэн дансны мэдээлэл ........ 17
3.8.Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........ 17
3.9.Аудитын илрүүлэлт ........ 18
Залруулсан алдаа ........ 18
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил ........ 18
Аудитын зөвлөмж ........ 18
3.10.Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд ........ 18
4.Менежментийн захидал ........ 19
5.Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт ........ 20

## 1.Төрийн аудитын санал, дүгнэлт

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34
Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2021.02.25 № 1-6/257

танай_____________-ны №_______________-т

АЙРАГ СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА А.ЭРДЭНЭЗАЯА ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Айраг сумын Засаг даргын Тамгын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Айраг сумын Засаг даргын Тамгын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Бусад мэдээлэл**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.
Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Т.ГАН-ӨЛЗИЙ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан
## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **155,700,604.03** | **151,470,184.03** |
| **33** | **АВЛАГА** | 55,140,957.00 | 21,362,535.00 |
| **335** | **Бусад авлага** | 55,140,957.00 | 21,362,535.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 55,140,957.00 | 21,362,535.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 100,559,647.03 | 130,107,649.03 |
| **351** | **Түүхий эд материал** | - | 6,181,600.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | - | 6,181,600.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 93,294,447.03 | 116,708,349.03 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,672,870.00 | 2,587,010.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 235,060.00 | 1,451,557.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 784,500.00 | 724,500.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | - | 4,619,900.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 90,602,017.03 | 107,325,382.03 |
| 35600 | Мал амьтад | 7,265,200.00 | 7,217,700.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **2,431,316,566.23** | **2,811,117,299.68** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 2,431,316,566.23 | 2,811,117,299.68 |
| **392** | **Биет хөрөнгө** | 2,323,020,149.50 | 2,637,859,757.93 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,641,644,087.00 | 1,800,470,659.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (40,378,004.55) | (133,438,753.41) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 250,772,800.00 | 294,332,800.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (112,882,296.75) | (148,527,863.31) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 251,794,028.92 | 294,301,779.77 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (170,781,324.14) | (190,295,747.72) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 64,824,228.72 | 65,323,728.72 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (32,689,553.44) | (37,565,779.89) |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 301,875,544.50 | 532,693,233.50 |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | (51,366,317.16) | (70,371,495.41) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 496,976,562.00 | 526,891,822.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (279,138,835.60) | (298,323,855.32) |
| 39217 | Ном | 2,369,230.00 | 2,369,230.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 108,296,416.73 | 173,257,541.75 |
| 39301 | Програм хангамж | 860,000.00 | 4,426,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (669,583.27) | (1,045,574.87) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 108,106,000.00 | 170,778,000.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | - | (900,883.38) |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **2,587,017,170.26** | **2,962,587,483.71** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **2,587,017,170.26** | **2,962,587,483.71** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 2,587,017,170.26 | 2,962,587,483.71 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 1,666,411,689.27 | 1,666,411,689.27 |
| 51101 | Өмч: - төрийн | 1,666,411,689.27 | 1,666,411,689.27 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 447,657,712.13 | 823,228,025.58 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 447,657,712.13 | 447,657,712.13 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 375,570,313.45 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 472,947,768.86 | 472,947,768.86 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **2,587,017,170.26** | **2,962,587,483.71** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **620,488,571.00** | **1,041,612,289.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **243,866,155.00** | **476,665,802.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 243,866,155.00 | 476,665,802.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 243,866,155.00 | 476,665,802.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 5,305,885.00 | 3,785,525.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 238,560,270.00 | 472,880,277.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **376,622,416.00** | **564,946,487.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 46,910,616.00 | 197,043,087.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 382,500.00 | 152,395,844.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 46,528,116.00 | 44,647,243.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 329,711,800.00 | 367,903,400.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 329,711,800.00 | 367,903,400.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **500,709,577.03** | **660,934,297.32** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **500,709,577.03** | **660,934,297.32** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 499,493,097.03 | 660,016,103.32 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 218,194,972.00 | 245,772,151.00 |
| 210101 | Үндсэн цалин | 218,194,972.00 | 244,721,491.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 1,050,660.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 27,330,089.00 | 30,798,057.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 18,930,436.00 | 21,123,500.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,118,235.00 | 2,371,364.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,689,012.00 | 1,967,400.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 416,041.00 | 491,800.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,176,365.00 | 4,843,993.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 26,330,499.00 | 32,496,555.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,982,377.00 | 6,934,915.00 |
| 210302 | Түлш, халаалт | 21,265,200.00 | 23,363,540.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,082,922.00 | 2,198,100.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 24,939,403.00 | 31,306,531.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,647,820.00 | 3,100,560.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 11,897,210.00 | 19,949,610.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,919,373.00 | 2,502,961.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 120,000.00 | 120,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 7,355,000.00 | 5,633,400.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 199,400.00 | 3,469,820.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 199,400.00 | 3,469,820.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 30,815,657.80 | 5,293,635.00 |
| 210604 | Урсгал засвар | 30,815,657.80 | 5,293,635.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 3,672,400.00 | 2,079,900.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,672,400.00 | 2,079,900.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 38,724,392.00 | 97,957,485.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 37,214,083.00 | 95,550,740.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 403,200.00 | 806,400.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 459,760.00 | 515,675.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 357,608.00 | 750,105.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 212,356.00 | 209,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 77,385.00 | 125,565.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 129,286,284.23 | 210,841,969.32 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 5,000,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 388,000.00 | 176,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 128,898,284.23 | 205,665,969.32 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 1,216,480.00 | 918,194.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 300,000.00 | 676,450.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 300,000.00 | 676,450.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 916,480.00 | - |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 916,480.00 | - |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | - | 241,744.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 241,744.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **119,778,993.97** | **380,677,991.68** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 85,518,195.96 | 5,107,678.23 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 85,518,195.96 | 5,107,678.23 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | (85,518,195.96) | (5,107,678.23) |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **34,260,798.01** | **375,570,313.45** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **401,748,802.00** | **623,872,969.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **5,305,885.00** | **3,785,525.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 5,305,885.00 | 3,785,525.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 5,305,885.00 | 3,785,525.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 5,305,885.00 | 3,785,525.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **396,442,917.00** | **620,087,444.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 66,731,117.00 | 252,184,044.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 382,500.00 | 152,395,844.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 66,348,617.00 | 99,788,200.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 329,711,800.00 | 367,903,400.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 329,711,800.00 | 367,903,400.00 |
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **396,276,202.00** | **484,699,765.00** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **396,276,202.00** | **484,699,765.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **340,218,765.00** | **462,313,016.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 218,194,972.00 | 245,772,151.00 |
| 210101 | Үндсэн цалин | 211,099,872.00 | 244,721,491.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 7,095,100.00 | 1,050,660.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 27,330,089.00 | 30,798,057.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 18,930,436.00 | 21,123,500.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,118,235.00 | 2,371,364.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,689,012.00 | 1,967,400.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 416,041.00 | 491,800.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,176,365.00 | 4,843,993.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 26,290,999.00 | 32,496,555.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,903,877.00 | 6,934,915.00 |
| 210302 | Түлш, халаалт | 21,265,200.00 | 23,363,540.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,121,922.00 | 2,198,100.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 16,590,913.00 | 25,229,591.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,446,200.00 | 3,515,600.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 10,406,860.00 | 18,291,030.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,919,853.00 | 2,502,961.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 120,000.00 | 120,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 698,000.00 | 800,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 199,400.00 | 6,093,400.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 199,400.00 | 6,093,400.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,672,000.00 | 1,970,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 292,000.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 2,380,000.00 | 1,970,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 3,672,400.00 | 2,079,900.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,672,400.00 | 2,079,900.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 39,879,992.00 | 112,201,362.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 38,369,683.00 | 109,794,617.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 403,200.00 | 806,400.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 459,760.00 | 515,675.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 357,608.00 | 750,105.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 212,356.00 | 209,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 77,385.00 | 125,565.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 5,388,000.00 | 5,672,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5,000,000.00 | 5,496,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 388,000.00 | 176,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **56,057,437.00** | **22,386,749.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | - | 782,470.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 782,470.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 56,057,437.00 | 21,604,279.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 56,057,437.00 | 241,744.00 |
| 213404 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | | 21,362,535.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **5,472,600.00** | **139,173,204.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **5,472,600.00** | **139,173,204.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **5,472,600.00** | **139,173,204.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 5,472,600.00 | 139,173,204.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 5,172,600.00 | - |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 300,000.00 | 139,173,204.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(5,472,600.00)** | **(139,173,204.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | - | - |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 1,666,411,689.27 | 514,001,996.42 | 372,342,686.56 | 2,552,756,372.25 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | 41,054,227.56 | 41,054,227.56 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | 1,666,411,689.27 | 514,001,996.42 | 413,396,914.12 | 2,593,810,599.81 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | (41,054,227.56) | - | (41,054,227.56) |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | - | - | - | - |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | 34,260,798.01 | 34,260,798.01 |
| C08 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 1,666,411,689.27 | 472,947,768.86 | 447,657,712.13 | 2,587,017,170.26 |
| D01 | **2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 1,666,411,689.27 | 472,947,768.86 | 447,657,712.13 | 2,587,017,170.26 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | 1,666,411,689.27 | 472,947,768.86 | 447,657,712.13 | 2,587,017,170.26 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | - | - | - |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | - | - |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - | - | - |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | 375,570,313.45 | 375,570,313.45 |
| D09 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 1,666,411,689.27 | 472,947,768.86 | 823,228,025.58 | 2,962,587,483.71 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 372,903,400.00 | 371,688,925.00 | 1,214,475.00 | 99.7 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 372,903,400.00 | 371,688,925.00 | 1,214,475.00 | 99.7 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 372,103,400.00 | 370,664,711.00 | 1,438,689.00 | 99.6 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 245,919,100.00 | 245,772,151.00 | 146,949.00 | 99.9 |
| 210101 | Үндсэн цалин | 244,863,100.00 | 244,721,491.00 | 141,609.00 | 99.9 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 1,056,000.00 | 1,050,660.00 | 5,340.00 | 99.5 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 30,960,300.00 | 30,798,057.00 | 162,243.00 | 99.5 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 21,123,500.00 | 21,123,500.00 | - | 100.0 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,459,200.00 | 2,371,364.00 | 87,836.00 | 96.4 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,967,400.00 | 1,967,400.00 | - | 100.0 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 491,800.00 | 491,800.00 | - | 100.0 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,918,400.00 | 4,843,993.00 | 74,407.00 | 98.5 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 32,996,700.00 | 32,496,555.00 | 500,145.00 | 98.5 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,409,200.00 | 6,934,915.00 | 474,285.00 | 93.6 |
| 210302 | Түлш, халаалт | 23,389,400.00 | 23,363,540.00 | 25,860.00 | 99.9 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,198,100.00 | 2,198,100.00 | - | 100.0 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 18,307,700.00 | 18,158,291.00 | 149,409.00 | 99.2 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,450,800.00 | 3,450,600.00 | 200.00 | 100.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 11,790,300.00 | 11,769,730.00 | 20,570.00 | 99.8 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,146,600.00 | 2,017,961.00 | 128,639.00 | 94.0 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 120,000.00 | 120,000.00 | - | 100.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 800,000.00 | 800,000.00 | - | 100.0 |
| **2105** | **Нормативт зардал** | 200,000.00 | 199,800.00 | 200.00 | 99.9 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 200,000.00 | 199,800.00 | 200.00 | 99.9 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 6,480,000.00 | 6,335,000.00 | 145,000.00 | 97.8 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 4,400,000.00 | 4,365,000.00 | 35,000.00 | 99.2 |
| 210604 | Урсгал засвар | 2,080,000.00 | 1,970,000.00 | 110,000.00 | 94.7 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,233,600.00 | 1,219,900.00 | 13,700.00 | 98.9 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,233,600.00 | 1,219,900.00 | 13,700.00 | 98.9 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 30,330,000.00 | 30,012,957.00 | 317,043.00 | 99.0 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 27,660,000.00 | 27,606,212.00 | 53,788.00 | 99.8 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 806,400.00 | 806,400.00 | - | 100.0 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 550,000.00 | 515,675.00 | 34,325.00 | 93.8 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 955,300.00 | 750,105.00 | 205,195.00 | 78.5 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 230,000.00 | 209,000.00 | 21,000.00 | 90.9 |
| 210807 | Газрын төлбөр | 128,300.00 | 125,565.00 | 2,735.00 | 97.9 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 5,676,000.00 | 5,672,000.00 | 4,000.00 | 99.9 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5,500,000.00 | 5,496,000.00 | 4,000.00 | 99.9 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 176,000.00 | 176,000.00 | - | 100.0 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 800,000.00 | 1,024,214.00 | (224,214.00) | 128.0 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 800,000.00 | 1,024,214.00 | (224,214.00) | 128.0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 800,000.00 | 782,470.00 | 17,530.00 | 97.8 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 241,744.00 | (241,744.00) | |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 372,903,400.00 | 371,688,925.00 | 1,214,475.00 | 99.7 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 367,903,400.00 | 367,903,400.00 | - | 100.0 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 367,903,400.00 | 367,903,400.00 | - | 100.0 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 5,000,000.00 | 3,785,525.00 | 1,214,475.00 | 75.7 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 5,000,000.00 | 3,785,525.00 | 1,214,475.00 | 75.7 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | | | |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү |
|---|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **-** | **252,184,044.00** | **(252,184,044.00)** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **-** | 252,184,044.00 | (252,184,044.00) |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | - | 230,821,509.00 | (230,821,509.00) |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | - | 7,071,300.00 | (7,071,300.00) |
| 210401 | Бичиг хэрэг | - | 65,000.00 | (65,000.00) |
| 210402 | Тээвэр, шатахуун | - | 6,521,300.00 | (6,521,300.00) |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | - | 485,000.00 | (485,000.00) |
| **2105** | **Нормативт зардал** | - | 5,893,600.00 | (5,893,600.00) |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | - | 5,893,600.00 | (5,893,600.00) |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | - | 860,000.00 | (860,000.00) |
| 210702 | Дотоод албан томилолт | - | 860,000.00 | (860,000.00) |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | - | 216,996,609.00 | (216,996,609.00) |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 216,996,609.00 | (216,996,609.00) |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **-** | 21,362,535.00 | (21,362,535.00) |
| 213405 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг | | 21,362,535.00 | (21,362,535.00) |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | - | **252,184,044.00** | **(252,184,044.00)** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | - | 252,184,044.00 | (252,184,044.00) |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 152,395,844.00 | (152,395,844.00) |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 99,788,200.00 | (99,788,200.00) |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | | |

## 3.Аудитын тайлан

### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Айраг сумын Засаг даргын Тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Тамгын газрын дарга А.Эрдэнэзаяа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд элэгдлээрээ анхны өртөө нөхсөн үндсэн хөрөнгө, орлогын төлөвлөгөөний талаар өгсөн зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 22-аас 2021 оны 02 дугаар сарын 25–ны хооронд аудитор Т.Мөнхтогтох хариуцаж хэрэгжүүлэв.

Айраг сумын Засаг даргын Тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 6/61 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Айраг сумын Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн санал хүсэлтийг шийдвэрлэж төрийн үйлчилгээг хүргэх.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна.

Үүнд:

- Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хууль;
- Төрийн аудитын тухай хууль;
- Татварын ерөнхий хууль;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль;
- Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоол “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”;
- Засгийн газрын 2020 оны 163 дугаар тогтоол “Төрийн албаны цалингийн нэгдсэн систем нэвтрүүлэх тухай”;

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Айраг сумын Засаг даргын Тамгын газрын газрын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

### 3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны хагас жилийн санхүүгийн тайлангийн нийт зардлын 371,205.8 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 3,712.1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон, гүйцэтгэлийн үе шатанд 6,660.4 мянган төгрөгөөр тооцож, баталгаажууллаа.

### 3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Айраг сумын Засаг даргын Тамгын газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 375,570.3 мянган төгрөгөөр буюу 14.5 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 0.0 | 0.0 | 0.0 |
| Авлага | 55,140.9 | 21,362.5 | -33,778.4 |
| Урьдчилгаа | 0.0 | 0.0 | 0.0 |
| Бараа материал | 100,559.6 | 130,107.6 | 29,548.0 |
| Үндсэн хөрөнгө | 2,431,316.6 | 2,811,117.3 | 379,800.7 |
| **Нийт хөрөнгө** | **2,587,017.1** | **2,962,587.4** | **375,570.3** |
| Өр төлбөр | 0.0 | 0.0 | 0.0 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 2,587,017.1 | 2,962,587.4 | 375,570.3 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **2,587,017.1** | **2,962,587.4** | **375,570.3** |

Авлага дансны үлдэгдэл 21,362.5 мянган төгрөг нь нэмэлт санхүүжилтийн үлдэгдлийг төвлөрүүлсэн авлага бөгөөд тайлант онд 33,778.4 мянган төгрөгөөр буурсан нь мөн нэмэлт санхүүжилтийн үлдэгдлийг буцаан олгосонтой холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 130,107.6 мянган төгрөг болж 29,548.0 мянган төгрөгөөр өссөн байна. Тодруулбал: Ковид-19 цар тахалтай холбоотой тусгай зориулалттай материалын дансанд маск бээлий зэрэг хөдөлмөр хамгааллын материал, бусад хангамжийн материалын дансанд өвс, хамгааллын хувцсыг бүрдүүлснээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,811,117.3 мянган төгрөг болж 379,800.7 мянган төгрөгөөр өссөн нь төрийн албан хаагчийн байр, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгүүд нэмэгдсэнээс шалтгаалжээ. Үндсэн хөрөнгийн данс нь хөрөнгө оруулалтаар 450,921.1 мянган төгрөг, урсгал төсвийн худалдан авалтаар 139,173.2 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн мянган төгрөгийн 480.0 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Үнэ төлбөргүй шилжүүлсэн хөрөнгө байхгүй, акталсан 18,209.6 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Биет бус хөрөнгө өссөн нь нутгийн удирдлагын ордны газар, тоглоомын талбайн газар, нийтийн эзэмшлийн газар, нисэх тэрэг буух хөөрөх талбайн газар нэмэгдсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,962,587.4 мянган төгрөг болж 375,570.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн өссөнөөс шалтгаалжээ.

Айраг сумын Засаг даргын Тамгын газрын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 421,123.7 мянган төгрөгөөр буюу 67.8 хувиар өссөн байна. Энэ нь нэмэлт санхүүжилтийн дансанд хандив тусламжийн орлого нэмэгдсэнээс мөн цагдаагийн пос машиныг сумын орлогод төвлөрүүлэн цагдаагийн тогтмол зардлуудыг төлсөнтэй холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 160,224.7 мянган төгрөгөөр буюу 31.9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин хөлс, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, хангамж материалын зардал, нормативт зардал, Засаг даргын нөөц хөрөнгийн зардлууд байна.

## 3.6. ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ, НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТ

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 401,233.9 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 401,233.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 35,962.8 мянган төгрөгөөр бууруулж 365,271.1 мянган төгрөгөөр баталсан бөгөөд төсвийн тодотголоор 372,903.4 мянган төгрөгөөр баталсан байна.

### Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 372,903.4 мянган төгрөгийн төсөв баталснаас 367,903.4 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 5,000.0 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 367,903.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, туслах үйл ажиллагааны орлого 3,785.5 мянган төгрөг, нийт 371,688,9 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 371,447.1 мянган төгрөгийг зарцуулж 241.7 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 371,688.9 мянган төгрөг буюу 99.6 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

### Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлого

Төсвийн тухай хуульд зааснаар 2020 онд туслах үйл ажиллагааны орлого 5,000.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 3,785.5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлсэн нь түрээсийн орлогын 50 хувийн аймагт төвлөрүүлсэнтэй холбоотой.

*Хүснэгт 2.* Төвлөрүүлэх орлого /мянган төгрөг/

| Орлогын төрөл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| Туслах үйл ажиллагааны орлого | 5,000.0 | 3,785.5 | 1,214.5 | 75 |
| **Нийт дүн** | 5,000.0 | 3,785.5 | 1,214.5 | 75 |

## Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 152,395.8 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 99,788.2 мянган төгрөг, нийт 252,184.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс бичиг хэргийн зардалд 65.0 мянган төгрөг, тээвэр шатахууны зардалд 6,521.3 мянган төгрөг, шуудан холбооны зардалд 485.0 мянган төгрөг, нормын хувцас зөөлөн эдлэлийн зардалд 5,893.6 мянган төгрөг, дотоод томилолтын зардалд 860.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд 216,996.6 мянган төгрөг нийт 230,821.5 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 21,362.5 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлжээ.

## 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 147 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроож мэдээлсэн мэдээлэл байхгүй байна.

## 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 45,158.0 мянган төгрөгийн зөрчилд 31,000.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн актыг хэрэгжүүлсэн байна. Аудитаар өгсөн 1 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

*Хүснэгт 3.* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 1 | 31,000.0 | 1 | 31,000.0 | - | - | - |
| Албан шаардлага | - | - | - | - | - | - | - |
| Зөвлөмж | 1 | 14,158.0 | 1 | 14,158.0 | - | - | - |
| Нийт дүн | 2 | 45,158.0 | 2 | 45,158.0 | - | - | - |

## 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,663.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 449.1 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 1 албан шаардлага хүргүүлж, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1,214.5 мянган төгрөгийн 2 зөвлөмж өглөө.

### Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн элэгдлийг шүүж үзэхэд 449.1 мянган төгрөгийн зам гүүрийн байгууламжийн элэгдлийг дутуу тооцсон байсныг залруулав.

### Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 1 албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Тээвэр шатахууны зардалд харьцуулалтын аргыг ашиглахгүйгээр шууд худалдан авалтыг хийсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 “харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар”, 33 дугаар зүйлийн 33.1 “бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртөг нь энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс хэтрээгүй тохиолдолд харьцуулалтын аргыг хэрэглэж болно”, Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4 “төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

### Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

## 3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

## 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

*1 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа*

*1.1 Илрүүлэлт:*

*Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 6 нэр төрлийн 233 ширхэг 352.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгө байна.*

*1.2 Эрсдэл:*

*Санхүүгийн тайлан үнэн зөв илэрхийлэгдэхгүй байх, дансны үнэ бодит үнэ цэнийн хооронд материаллаг зөрүү үүсэх.*

*1.3 Өгсөн зөвлөмж:*

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2 *“илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох”* гэсэн заалттай нийцэхгүй байна.

*Ашиглах боломжтой боловч ашиглалтын хугацаа дууссан хөрөнгийг үнэлж бүртгэх, шаардлага хангаагүй хөрөнгийг акталж данснаас хасах арга хэмжээ авч ажиллах.*

*2 Орлогын данстай холбоотой асуудал*

*2.1 Илрүүлэлт:*

*Батлагдсан орлогын төлөвлөгөө 5.0 сая төгрөг, гүйцэтгэл 3.8 сая төгрөг, орлого 1.2 сая төгрөгөөр тасарсан байна.*

*2.2 Эрсдэл:*

*Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр дутагдах.*

*2.3 Өгсөн зөвлөмж:*

*Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1 “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэж заасантай нийцэхгүй байна.*

*Батлагдсан орлогын төлөвлөгөөг биелүүлэх талаар арга хэмжээ авч ажиллах.*

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

*Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.*

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

| Огноо: | Аудитын нэр: | Айраг сумын Засаг даргын Тамгын газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит | Аудитын код: |
|---|---|---|---|
| 2021.02 | | | ДГА-2021/3/СТА-ТШЗ |
| Шалгагдсан байгууллагын нэр: | Айраг сумын Засаг даргын Тамгын газар | | мянган төгрөгөөр |

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | Нэр | Албан тушаал | Овог нэр |
| *0* | *1* | *2* | *3* | *4* | *5* |
| 1 | Тээвэр шатахууны зардалд харьцуулалтын аргыг ашиглахгүйгээр шууд худалдан авалтыг хийсэн байна. | - | Албан шаардлага өгөх | Дарга<br>нягтлан бодогч | А.Эрдэнэзаяа<br>Ө.Ариунцэцэг |
| 2 | Үндсэн хөрөнгийн үлдэгдлийг шүүж үзэхэд байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 6 нэр төрлийн 233 ширхэг 352.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгө байна. | - | Зөвлөмж өгөх | Дарга<br>нягтлан бодогч | А.Эрдэнэзаяа<br>Ө.Ариунцэцэг |
| 3 | Батлагдсан орлогын төлөвлөгөө 5.0 сая төгрөг, гүйцэтгэл 3.8 сая төгрөг, орлого 1.2 сая төгрөгөөр тасарсан байна. | 1,214.5 | Зөвлөмж өгөх | Дарга<br>нягтлан бодогч | А.Эрдэнэзаяа<br>Ө.Ариунцэцэг |
| 4 | Үндсэн хөрөнгийн элэгдлийг шүүж үзэхэд 449.1 мянган төгрөгийн зам гүүрийн байгууламжийн элэгдлийг дутуу бодуулсан байна. | 449.1 | Залруулга | Дарга<br>нягтлан бодогч | А.Эрдэнэзаяа<br>Ө.Ариунцэцэг |
| **ДҮН** | | **1,663.6** | - | | |